



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 1/125

Есөнбулаг сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан "Говь-Алтай 80+" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангуулах, эрүүл ахуйн хяналт, урьдчилан сэргийлэх үзлэг хийх, зөвлөн туслах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Энхнаран	(аймгийн Нийгмийн салбарын төсөл, хөтөлбөрийн удирдагч)
Гишүүд:	Н.Алтанбагана	(Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Р.Болор	(Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Р.Цэнд-Аюуш	(Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	Х.Лхагважав	(Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	Н.Цогтбаяр	(аймгийн Ерөнхий прокурор) (зөвшилцснөөр)
	П.Мөнхзаяа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
	Э.Танхилмаа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)
	П.Булган	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын

8202100017

- Г.Золзая (Хяналтын улсын байцаагч)  
(Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)
- Б.Мөнхсайхан (Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч)
- М.Долгорсүрэн (Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)
- Ц.Түмэнжаргал (Боловсрол, шинжлэх ухааны газрын Боловсролын хяналтын улсын байцаагч )
- Х.Маралмаа (Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)
- Ц.Наранчимэг (Стандарт хэмжил зүйн хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн)
- Б.Өрнөхбаяр (Стандарт хэмжил зүйн хэлтсийн сорилтын нэгдсэн лабораторийн эрхлэгч)
- Б.Оюунцэцэг (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)
- Л.Цэнд-Аюуш (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)
- Б.Даваасамба (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
- О.Мөнхбаатар (Эрүүл мэндийн газрын хяналтын хэлтсийн дарга, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
- А.Сувданчимэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн дарга)

Нарийн бичиг:

2.Хоол үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчид, үйлчилгээний газруудад хийх хяналт, шалгалтыг чанартай зохион байгуулж, шалгалтын дүнг нэгтгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Э.Энхнаран)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ